



ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР
ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ДАРГЫН
ТУШААЛ

2021 оны 05 сарын 07 өдөр

Дугаар A/01

Улаанбаатар хот

Үнэлгээний хороо байгуулах
тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 10 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалт, Иргэний нисэхийн үндэсний төвийн дүрмийн 5.4.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Нисэхийн мэдээллийн үйлчилгээний автомат системийн (eAIS) шинэчлэлт” нийлүүлэх нийлүүлэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Үнэлгээний хорооны дарга:

Г.Мөнгөнхуяг

Агаарын навигацийн үйлчилгээний газрын дэд дарга

Нарийн бичгийн дарга:

С.Наранбаатар

Худалдан авах ажиллагааны тасгийн мэргэжилтэн

Гишүүд:

Д.Лхагважав

Агаарын навигацийн үйлчилгээний газрын үйлдвэрлэл хариуцсан менежер

А.Ванданмагсар

Иргэний нисэхийн залуучуудын холбооны гишүүн

М.Оргил

“Сэтгэл зүй, судалгаа мэдээллийн төв” төрийн бус байгууллагын судлаач

2. Нийлүүлэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Үнэлгээний хороо (Г.Мөнгөнхуяг)-нд үүрэг болгосугай.

3. Төндер болон сонгон шалгаруулалттай холбоотой баримт бичгээр архивын нэгж бүрдүүлж, холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөх, төндер нээхэд Үнэлгээний хорооны гишүүдээс ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийг гаргуулан Хуулийн хэлтэст хүргүүлэхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (С.Наранбаатар)-д даалгасугай.

ДАРГА

П.МОНХЖАРГАЛ

